

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал	10
3.1	(Аудитын чиглэл)	12
3.1.1	Илрүүлэлт:	12
3.1.2	Эрсдэл:	12
3.1.3	Өгсөн зөвлөмж:	12
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	13
3.2	(Аудитын чиглэл)	13
3.2.1	Илрүүлэлт:	13
3.2.2	Эрсдэл:	14
3.2.3	Өгсөн зөвлөмж:	14
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	14
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
4.6	Аудитлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлан	21
4.7	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.22 № 06/2019
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн Захирал Б.Даваажавд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 20-ноос 2019 оны 02 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баян суварга аудит ХХКомпаны аудитор Н.Бат-Оюун хариуцаж хэрэгжүүлэв.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/14 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж нь “Өндөр шаардлага бүхий ажлын байрны эрэлтэд нийцсэн мэргэжлийн өндөр ур чадвар, дадал, зөв төлөвшилтэй мэргэжилтэн бэлтгэх” зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын 2012 оны 19 дүгээр тушаалаар Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мэргэжил эзэмшүүлэх, техникийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулах.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын Төсвийн тухай хууль
- Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль
- Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам */Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан А/198/215 тушаал*
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/21 тоот тушаал *"Мэргэжлийн болон техник боловсролын сургалтын байгууллагын бүтэц орон тоо батлах тухай"*.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсөл арга хэмжээний санхүүжилтээс хичээлийн байрны их засварын ажилд зориулан 100.0 сая төгрөгийг авч, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер шалгаруулалтаар гүйцэтгэгчийг сонгон гүйцэтгүүлсэн.

2018-2019 оны хичээлийн жилд шинээр Тогоочийн анги нээн 31 суралцагч элсүүлэн, шинэ тоног төхөөрөмжөөр хангасан.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж, БНСУ-ын Кён-Ин Эмэгтэйчүүдийн их сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.

Тус коллеж нь барилга байгууламж, газрын дахин үнэлгээ хийж биет бус хөрөнгөнд, 12,000 м.кв талбай бүхий газрын эзэмших ашиглах эрхийн 264,960.0 мянган төгрөгийг, барилга байгууламжид 5,063,794.5 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгөнд */дулааны шугам, цэвэр, бохир усны шугам, спорт иж бүрэн талбай, гадна хашаа, талбай, машины зогсоол/* 263,799.2 мянган төгрөгийг тус тус үндсэн хөрөнгийн тайланд нэмэгдүүлэн тусгасан байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Хөдөлмөрийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/218 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байна.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитын томилогдсон баг гүйцэтгэлээ.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Санхүүгийн тооцоолох компанийн "Acolous" програмыг ашиглан санхүүгийн тайлан гаргаж байна.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 22 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 11 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Төсвийн тухай хуулийн төсөвт зардлын үр дүнд хариуцлага тооцохтой холбоотой юм.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2018 оны төсвийн гүйцэтгэлийн нийт зардал 2,758,559.0 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 55,171.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс 2 хувиар тооцсон нь тус коллежийн санхүүгийн тайланг бүрэн хамруулах зорилгоор төсөвт зардлын хувьд дүгнэлт гаргахад материаллаг түвшинг бага хувиар тооцох нь зохимжгүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 11 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 17 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	36,478.1	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	3	36,478.1	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, норм нормативын мөрдөлтийг шалгах.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал үгүй байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 9 хөтөлбөр, 68 арга хэмжээнд зориулан 2018 онд 2,151,285.1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 2,150,351.9 мянган төгрөг буюу 99.9 хувьтай тайлагнагдаж, 933.2 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна. Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 245.2 мянган төгрөг, гүйцэтгэлээр 262.4 мянган төгрөг болж 17.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Энэ нь тайлант онд орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 156.8 мянган төгрөгөөр бууруулж баталсан, мөн суралцагчдын элсэлтийн тоо нэмэгдсэн зэргээс шалтгаалсан байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус коллеж нь Шилэн дансны хуулиар 2018 онд давхардсан тоогоор 12 төрлийн 140 мэдээллийг оруулж хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1. Илрүүлэлт:

Улаанбаатар Бүсийн арга зүйн төвөөс 2018 оны 3, 4, 6 дугаар саруудад нийт 4 удаагийн Багшлах эрхийн сургалтыг зохион байгуулж, сургалтын төлбөрт бүгд 21,900.0 мянган төгрөгийг касс орлого авч зарцуулсан байна.

Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаанаас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг (түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй) ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. Эрсдэл:

Холбогдох хууль эрхийн актууд зөрчигдөж, бэлэн мөнгөний ашиглал, шамшигдал үүсэх, мөнгөн хөрөнгийн тайлан тооцоонд бүртгэлээр тавих дотоод хяналт суларч, санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх.

3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдөж, кассын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах

4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

3.2. Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1. Илрүүлэлт:

Германы GIZ байгууллагын төслийн санхүүжилтээр 2018 оны 01 дүгээр сард нийт 2,417.50 еврогийн үнэ бүхий тавилга ирсэнийг 2,417.5 мянган төгрөгөөр тооцон орлого авсан байна

Аудитын дахин тооцооллоор тухайн өдрийн Монгол банкны ханшаар тооцоход нийт үнэ 7,158.2 мянган төгрөг болж үнийн зөрүү 4,740.7 мянган төгрөгөөр дутуу үнээр бүртгэж тайлагнасныг тогтоож, санхүүгийн тайлан, тодруулгад холбогдох залруулгыг хийлгэсэн болно.

Энэ нь тухайн ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль тогтоомж болон холбогдох хууль тогтоомжоор олгогдсон эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм журамд нийцэж байх гэсэн санхүүгийн тайлагналын "үнэн зөв байх", "үнэлгээ" батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

2. Эрсдэл:

Төрийн мэдлийн өмч хөрөнгийн бүртгэл, тайлан тооцоонд бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3. Өгсөн зөвлөмж:

Цаашид хандив, тусламж, төслийн хүрээнд валютаар үнэлэгдсэн хөрөнгийг тухайн өдрийн Монгол банкны ханшаар тооцон орлогод авч, хөрөнгийн бүртгэл тайлан тооцоонд тавих дотоод хяналтыг сайржуулж ажиллахыг тус коллежийн удирдлагад зөвлөмж болгох.

4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

3.3 Өр төлбөртэй холбоотой асуудал

1. Илрүүлэлт:

Тус коллеж 2018 оны эцэст ХХОАТ-т 9,837.4 мянган төгрөгийн өглөгтэйгээр тайлагнасан бөгөөд өмнөх оноос 1,883.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

2. Эрсдэл:

Холбогдох хууль эрхийн акт зөрчигдөж, тайлан тооцоонд бүртгэлээр тавих хяналт сулрах.

3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, үүссэн өр төлбөрийг тайлант хугацаанд нь барагдуулж ажиллах.

4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 8 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>207,324,826.93</u>	<u>307,280,390.30</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	207,324,826.93	307,280,390.30
351	Түүхий эд материал	153,044,847.50	219,061,771.00
35110	Тусгай зориулалттай материал	152,544,847.50	218,561,771.00
35130	Эм боох материал	500,000.00	500,000.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	00.00	00.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	28,600.00	14,601,103.00
354	Хангамжийн материал	24,934,707.90	72,672,516.30
35410	Бичиг хэргийн материал	777,900.00	534,800.00
35420	Аж ахуйн материал	23,643,277.90	42,457,537.90
35430	Сэлбэг хэрэгсэл	278,540.00	3,133,188.40
35470	Бусад хангамжийн материал	234,990.00	26,546,990.00
35500	Биологийн хөрөнгө	28,371,671.53	00.00
35600	Мал амьтад	945,000.00	945,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,067,831,708.74</u>	<u>8,228,778,591.92</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,067,831,708.74	8,228,778,591.92
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	3,045,428,363.32	7,949,976,441.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,936,661,114.00	6,070,215,210.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,989,188,582.68	-56,209,410.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	126,730,000.00	111,610,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-65,051,444.59	-63,549,111.31
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,633,918,634.81	3,679,672,946.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2,081,127,879.30	-2,514,677,434.39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	592,485,631.39	633,908,031.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	-324,470,798.84	-382,317,083.58
39214	Бусад үндсэн хөрөнгө	115,776,432.80	334,251,182.55
39215	Хуримтлагдсан элэгдэл	-81,811,640.76	-44,434,786.39
39217	Ном	181,506,896.49	181,506,896.49
393	Биет бус хөрөнгө	<u>22,403,345.42</u>	<u>278,802,150.02</u>
39301	Програм хангамж	68,019,784.83	68,019,784.83
39302	Хуримтлагдсан элэгдэл	-45,616,439.41	-54,177,634.81
39303	Бусад биет бус хөрөнгө /Газар эзэмших эрх/	00.00	264,960,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,275,156,535.67</u>	<u>8,536,058,982.22</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>35,869,439.05</u>	<u>9,837,410.70</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	35,869,439.05	9,837,410.70
413	Өглөг	35,869,439.05	9,837,410.70
413103	Татварын өглөг /ТӨҮГ/	7,953,607.15	9,837,410.70
413102	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	27,915,831.90	00.00

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,239,287,096.62	8,526,221,571.52
51	Засгийн газрын хувь оролцоо	3,239,287,096.62	8,526,221,571.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,525,269,411.59	2,939,702,673.59
51101	Өмч: - төрийн	2,525,269,411.59	2,939,702,673.59
512	Хуримтлагдсан үр дүн	436,904,585.03	131,285,372.76
51210	Өмнөх үеийн үр дүн	436,904,585.03	436,904,585.03
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-305,619,212.27
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	277,113,100.00	5,455,233,525.17
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,275,156,535.67	8,536,058,982.22

4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,430,188,460.26	2,452,939,815.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	728,629,510.00	490,393,295.02
120	Нийтлэг татварын бус орлого	728,629,510.00	490,393,295.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	725,146,240.00	490,393,295.02
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	292,131,300.00	239,476,759.60
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,540,540.00	45,681,768.42
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	407,474,400.00	205,234,767.00
120009	Бусад орлого	3,483,270.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,701,558,950.26	1,962,546,520.40
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,696,148,950.26	1,906,285,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,702,964,700.00	1,906,285,100.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	-6,815,749.74	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,410,000.00	56,261,420.40
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	8,720,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид олгосон		4,760,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,350,000.00	42,781,420.40
131106	Төсвийн урамшуулал	60,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,856,328,567.45	2,758,559,027.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,856,328,567.45	2,758,559,027.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,739,049,587.45	2,653,660,492.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,309,953,862.00	1,364,399,660.02
210101	Үндсэн цалин	956,600,862.00	1,002,111,762.02
210102	Нэмэгдэл	275,489,500.00	284,424,398.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	77,863,500.00	77,863,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,941,322.58	168,605,539.63
210201	Тэтгэврийн даатгал	149,941,322.58	113,923,739.63
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	13,670,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	10,936,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	2,734,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	27,340,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,774,122.29	120,522,886.92
210301	Гэрэл, цахилгаан	44,556,200.10	48,648,781.30
210302	Түлш, халаалт	37,352,025.72	54,534,548.00
210303	Цэвэр, бохир ус	17,865,896.47	17,339,557.62
210304	Байрны түрээс	00.00	00.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,704,766.62	17,260,850.02
210401	Бичиг хэрэг	1,449,483.00	2,405,910.00

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	7,700,000.00	3,820,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,101,472.86	7,365,332.02
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,180,000.00	2,432,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,273,810.76	1,237,108.00
2105	Нормативт зардал	76,570,555.00	79,589,330.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	367,700.00	248,010.00
210502	Хоол, хүнс	76,202,855.00	78,332,320.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,009,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,960,970.00	5,693,970.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	55,600.00	1,885,440.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,534,300.00	844,810.00
210604	Урсгал засвар	51,371,070.00	2,963,720.00
2107	Томилолт, зочны зардал	2,882,960.00	2,823,800.00
210702	Дотоод албан томилолт	2,882,960.00	2,823,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,423,430.00	57,621,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,470,000.00	50,400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,970,000.00	2,970,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	716,430.00	2,683,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	267,000.00	202,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	880,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	486,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	963,837,598.96	837,142,556.02
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	175,860,876.60	219,318,806.03
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	787,976,722.36	617,823,749.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	117,278,980.00	104,898,535.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	117,278,980.00	86,547,370.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	64,399,580.00	58,765,470.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,979,400.00	27,781,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,900,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	18,351,165.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	18,351,165.08
213304	Хөрөнгийн	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-426,140,107.19</u>	<u>-305,619,212.27</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-426,140,107.19</u>	<u>-305,619,212.27</u>

4.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,019,230,790.26	2,246,864,520.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	317,671,840.00	284,318,000.02
120	Нийтлэг татварын бус орлого	317,671,840.00	284,318,000.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	317,671,840.00	284,318,000.02
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	292,131,300.00	239,476,759.60
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,540,540.00	44,841,240.42
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,701,558,950.26	1,962,546,520.40
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,696,148,950.26	1,906,285,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,702,964,700.00	1,906,285,100.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	-6,815,749.74	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,410,000.00	56,261,420.40
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	8,720,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид олгосон		4,760,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,350,000.00	42,781,420.40
131106	Төсвийн урамшуулал	60,000.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,018,847,790.26	2,210,951,008.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,018,847,790.26	2,210,951,008.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,901,568,810.26	2,106,052,473.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,301,830,422.17	1,392,299,300.00
210101	Үндсэн цалин	1,301,830,422.17	1,030,011,700.00
210102	Нэмэгдэл	00.00	284,424,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	77,863,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	131,712,535.34	165,897,400.00
210201	Тэтгэврийн даатгал	131,712,535.34	111,046,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	13,839,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	10,936,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	2,734,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	27,340,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,774,122.29	120,522,886.92
210301	Гэрэл, цахилгаан	44,556,200.10	48,648,781.30
210302	Түлш, халаалт	37,352,025.72	54,534,548.00
210303	Цэвэр, бохир ус	17,865,896.47	17,339,557.62
2104	Хангамж, бараа материалын зардал	25,543,091.86	26,649,647.02
210401	Бичиг хэрэг	4,996,969.00	5,429,470.00
210402	Тээвэр, шатахуун	5,310,000.00	5,360,000.00

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,101,472.86	7,369,072.02
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,180,000.00	2,432,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,954,650.00	6,058,605.00
2105	Нормативт зардал	86,748,455.00	88,972,607.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,470,200.00	628,427.00
210502	Хоол, хүнс	76,202,855.00	78,332,320.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,075,400.00	10,011,860.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,198,198.00	75,971,228.40
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,815,118.00	9,068,088.40
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,945,180.00	2,730,210.00
210604	Урсгал засвар	26,437,900.00	64,172,930.00
2107	Томилолт, зочны зардал	2,882,960.00	2,823,800.00
210702	Дотоод албан томилолт	2,882,960.00	2,823,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,423,430.00	57,135,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,470,000.00	50,400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,970,000.00	2,970,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	716,430.00	2,683,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	267,000.00	202,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	880,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	164,455,595.60	175,780,504.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	164,455,595.60	175,780,504.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	117,278,980.00	104,898,535.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	117,278,980.00	86,547,370.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	64,399,580.00	58,765,470.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,979,400.00	27,781,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,900,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	18,351,165.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	18,351,165.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>383,000.00</u>	<u>35,913,512.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>383,000.00</u>	<u>35,913,512.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>383,000.00</u>	<u>35,913,512.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>383,000.00</u>	<u>35,913,512.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	383,000.00	35,913,512.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-383,000.00</u>	<u>-35,913,512.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,525,269,411.59	277,113,100.00	862,790,652.22	00.00	3,665,173,163.81
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	254,040.00	00.00	254,040.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,525,269,411.59	277,113,100.00	863,044,692.22	00.00	3,665,427,203.81
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-426,140,107.19	00.00	-426,140,107.19
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,525,269,411.59	277,113,100.00	436,904,585.03	00.00	3,239,287,096.62
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,525,269,411.59	277,113,100.00	436,904,585.03	00.00	3,239,287,096.62
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,525,269,411.59	277,113,100.00	436,904,585.03	00.00	3,239,287,096.62
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	414,433,262.00	5,178,120,425.17	00.00	00.00	5,592,553,687.17
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-305,619,212.27	00.00	-305,619,212.27
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,939,702,673.59	5,455,233,525.17	131,285,372.76	00.00	8,526,221,571.52

4.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,151,453,600.00	2,150,351,936.94	-1,101,663.06	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,151,453,600.00	2,150,351,936.94	-1,101,663.06	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,083,618,800.00	2,082,517,136.94	-1,101,663.06	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,392,299,000.00	1,392,299,300.00	300.00	100.0
210101	Үндсэн цалин	1,030,011,400.00	1,030,011,700.00	300.00	100.0
210102	Нэмэгдэл	284,424,400.00	284,424,400.00	00.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	77,863,200.00	77,863,200.00	00.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,066,400.00	165,897,400.00	-169,000.00	99.9
210201	Тэтгэврийн даатгал	111,215,600.00	111,046,600.00	-169,000.00	99.8
210202	Тэтгэмжийн даатгал	13,839,500.00	13,839,500.00	00.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,936,300.00	10,936,300.00	00.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,734,100.00	2,734,100.00	00.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	27,340,900.00	27,340,900.00	00.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,001,700.00	120,522,886.92	-478,813.08	99.6
210301	Гэрэл, цахилгаан	43,312,700.00	48,648,781.30	5,336,081.30	112.3
210302	Түлш, халаалт	60,859,000.00	54,534,548.00	-6,324,452.00	89.6
210303	Цэвэр, бохир ус	16,830,000.00	17,339,557.62	509,557.62	103.0
2104	Хангамж, бараа материалын зардал	27,139,700.00	27,139,637.02	-62.98	100.0
210401	Бичиг хэрэг	4,207,500.00	5,429,470.00	1,221,970.00	129.0
210402	Тээвэр, шатахуун	4,207,500.00	5,360,000.00	1,152,500.00	127.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,428,000.00	7,369,072.02	-4,058,927.98	64.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,880,000.00	2,432,500.00	-447,500.00	84.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,416,700.00	6,548,595.00	2,131,895.00	148.3
2105	Нормативт зардал	89,058,600.00	88,972,607.00	-85,993.00	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	943,000.00	628,427.00	-314,573.00	66.6
210502	Хоол, хүнс	78,403,000.00	78,332,320.00	-70,680.00	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,712,600.00	10,011,860.00	299,260.00	103.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,402,600.00	71,402,380.00	-220.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,524,500.00	4,499,240.00	1,974,740.00	178.2
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,346,000.00	2,730,210.00	-2,615,790.00	51.1
210604	Урсгал засвар	63,532,100.00	64,172,930.00	640,830.00	101.0
2107	Томилолт, зочны зардал	2,883,400.00	2,823,800.00	-59,600.00	97.9

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	2,883,400.00	2,823,800.00	-59,600.00	97.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,429,000.00	57,135,100.00	-293,900.00	99.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,400,000.00	50,400,000.00	00.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,970,000.00	2,970,000.00	00.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	2,684,000.00	2,683,100.00	-900.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	495,000.00	202,000.00	-293,000.00	40.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	880,000.00	880,000.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	156338400.00	156324026.00	-14,374.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	156,338,400.00	156,324,026.00	-14,374.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,834,800.00	67,834,800.00	00.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,834,800.00	67,834,800.00	00.00	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	40,052,900.00	40,052,900.00	00.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,781,900.00	27,781,900.00	00.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	21,900,000.00	21,900,000.00	00.0
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	21,900,000.00	21,900,000.00	00.0
223001	Бусад хөрөнгө	00.00	21,900,000.00	21,900,000.00	00.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,396,473,250.00	2,150,351,936.94	246,121,313.06	89.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,151,285,100.00	1,887,933,936.92	263,351,163.08	87.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,151,285,100.00	1,887,933,936.92	263,351,163.08	87.8
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	245,188,150.00	262,418,000.02	17,229,850.02	107.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	215,000,000.00	239,476,759.60	24,476,759.60	111.4
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,188,150.00	22,941,240.42	-7,246,909.58	76.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00	00.00	00.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00	00.00	00.0
610001	Төсвийн байгууллага	1	1	00.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	145	145	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	4	4	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	130	130	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	11	11	00.00	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,626	1,626	00.00	100.0
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	1,626	1,626	00.00	100.0
632001	Төрийн өмчит МСҮТ	1,626	1,626	00.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	145	145	00.00	100.0

4.6 АУДИТЛАГДСАН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
21	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		56,261,418.40	56,261,418.40	-
210	Урсгал зардлын дүн		56,261,418.40	56,261,418.40	-
2106	Бараа үйлчилгээний зардал		37,648,848.40	37,648,848.40	-
210601	Багаж, техник, хэрэгсэл		24,068,848.40	24,068,848.40	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		13480000.00	13,480,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		13,480,000.00	13,480,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		18,712,570.00	18,712,570.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг		18,712,750.00	18,712,750.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		18,712,750.00	18,712,750.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		56,261,420.40	56,261,420.40	-
131001	Нэмэлт санхүүжилтийн орлого		56,261,420.40	56,261,420.40	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит этгээдээс авсан хандив тусламж		8,720,000.00	-8,720,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид олгосон		4,760,000.00	-4,760,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		42,781,420.40	42,781,420.40	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		00.00	00.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		00.00	00.00	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		00.00	00.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО		1		
610001	Төсвийн байгууллага		1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО		145		
620001	Удирдах ажилтан		4		
620002	Гүйцэтгэх ажилтан		130		
620003	Үйлчлэх ажилтан		11		
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)		1,626		
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ		1,626		

4.7 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2019.02.22			САГ-2019/187/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	З	4	5	9	10
1	Улаанбаатар Бүсийн арга зүйн төвөөс 2018 оны 3, 4, 6 дугаар саруудад нийт 4 удаагийн Багшлах эрхийн сургалтыг зохион байгуулж, сургалтын төлбөрт бүгд 21,900.0 мянган төгрөгийг касст орлого авч зарцуулсан байна	21,900.0	Зөвлөмж өгөх	ҮУПТК-ийн захирал, ерөнхий нягтлан бодогч	Б.Даваажав П.Сарантуяа
2	Германы GIZ байгууллагын төслийн санхүүжилтээр 2018 оны 01 дүгээр сард нийт 2,417.50 еврогийн үнэ бүхий тавилга ирсэнийг 2,417.5 мянган төгрөгөөр тооцон орлого авсан байна.	4,740.7	Зөвлөмж өгөх	ҮУПТК-ийн захирал, ерөнхий нягтлан бодогч	Б.Даваажав П.Сарантуяа
3	Тус коллеж 2018 оны эцэст ХХОАТ-т 9,837.4 мянган төгрөгийн өглөгтэйгээр тайлагнасан бөгөөд өмнөх оноос 1,883.3 мянган төгрөгөөр өссөн байна	9,837.4	Зөвлөмж өгөх	ҮУПТК-ийн захирал, ерөнхий нягтлан бодогч	Б.Даваажав П.Сарантуяа
	Дүн	36,478.1			